

**2010 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛД МОНГОЛ УЛС
ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ***Г.Онон**

- 2010.06.22-24 Бүгд Найрамдах Итали Улсад ажлын айлчлал хийж буй Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар Италийн Гадаад хэргийн сайд Ф.Фраттинитэй албан ёсны уулзалт хийв. Уулзалтаар Монгол-Италийн хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн жил болж байгааг цохон тэмдэглээд цаашид харилцаагаа улам эрчимжүүлэх бодлоготой байгаагаа илэрхийллээ. Мөн Европын холбооны стандартыг манай нийгэм-эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэх, хоёр талын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс эдийн засгийн томоохон арга хэмжээг Итали Улсад зохион байгуулах, соёл боловсролын салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, ялангуяа захиргааны чиглэлийн мэргэжилтнүүдийг сургах зэрэг асуудлаар дэлгэрэнгүй санал солилцов. Уулзалтын үеэр Гадаад хэргийн сайд Ф.Фраттини БНИУ-ын Ерөнхийлөгчөөс хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид илгээсэн мэндчилгээ болон түүнийг БНИУ-д айлчлахыг урьсан урилгыг албан ёсоор гардуулав. Айлчлалын үеэр Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Италийн Гадаад худалдааны комисс хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт ГХОГ-ын дарга Б.Ганзориг, Италийн Гадаад худалдааны комиссын дарга У.Ваттани нар гарын үсэг зурав. Мөн айлчлалын үеэр Ром хотноо байрладаг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэд ерөнхий захирал Хэ Чангчүй, Хөдөө, аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн дэд ерөнхийлөгч Ю.Омура, Италийн бичил зээлийн үндэсний хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Р.Грациано, Ром хотын захирагч Жианни Алимано зэрэг албаны хүмүүстэй уулзаж хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.
- 2010.06.24 Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбат Мексикийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Ф.Калдеронд Итгэмжлэх жуух бичгээ барив. Элчин сайд Х.Бэхбатыг ИЖБ-гээ барьсантай нь холбогдуулан Ерөнхийлөгч Ф.Калдерон, Гадаад хэргийн сайд хатагтай Патрисиа Эспиноса нар хүлээн авч уулзаж, хоёр талын харилцааны асуудлаар Санал солилцов.

* Г.Онон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

- 2010.06.29-30 Монгол Улсын Засгийн газрын урилгаар Саудын Арабын Газрын тос, эрдэс баялгийн сайд Али Ибрахим Аль-Наими тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Энэхүү айлчлал нь Монгол Улс, Саудын Арабын Вант Улсын хооронд 2007 оны 2 дугаар сарын 12-нд дипломат харилцаа тогтоосноос хойш Саудын Арабын Засгийн газрын гишүүний хэмжээнд хийсэн анхны айлчлал болсноороо ач холбогдолтой болов. Айлчлалын үеэр Саудын Арабын Газрын тос, эрдэс баялгийн сайд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод бараалхаж, хоёр орны хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг татах гэх зэрэг асуудлаар санал бодлоо солилцсон бөгөөд Саудын Арабын Цог жавхлант Ван Абдулла бин Абдулазиз Аль-Сауд болон Саудын Арабын Үе залгамжлах хунтайж Султан бин Абдулазиз Аль-Сауд нарын мэндчилгээг Монгол Улсын Ерөнхий сайдад уламжлав. Мөн Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригттой уулзаж албан ёсны яриа хэлцээ хийв.
- 2010.06.30-07.01 Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын ээлжит V хуралдаан болов. Комиссын хуралдааныг Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Комиссын Монголын хэсгийн дарга С.Ламбаа, БНБУ-ын Эдийн засаг, эрчим хүч, аялал жуулчлалын дэд сайд, Комиссын Болгарын хэсгийн дарга Иво Маринов нар тус тус тэргүүлэв. Комиссын хуралдааны үеэр хүнс, хөдөө аж ахуй, геологи, уул уурхай, эрчим хүч, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлах зэрэг асуудлыг хэлэлцэж хоёр тал Монгол, Болгарын харилцаа, хамтын талын болон Европын Холбооны хүрээнд хамтран ажиллах боломж, цаашид авах арга хэмжээ болон Европын Холбооны стандартыг Монголд нэвтрүүлэх талаар Европын Холбооноос тусламж үзүүлэхээр болсонтой холбогдуулан Болгарын талтай хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцож хэлэлцсэн асуудлаар комиссын хуралдааны Протокол байгуулж Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - “Жижиг, дунд үйлдвэрийн газар”, БНБУ-ын “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих агентлаг” хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурав.
- 2010.07.05 НҮБ-ын Дүрвэгсдийн дээд комиссарын газрын Бээжин дэх Бүсийн төлөөлөгч ноён Джессепе Де Винсентиис Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт Итгэмжлэх

- захидлаа гардуулав. Шинэ ажилд томилогдсонтой нь холбогдуулан Гадаад харилцааны сайд түүнд баяр хүргээд НҮБ-ын ДДКГ, Монгол Улсын Засгийн газрын хоорондын хамтын ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын талаар санал солилцов.
- 2010.07.16 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсад суух Суурин төлөөлөгч бөгөөд НҮБ-аас Монгол Улсад суух Суурин зохицуулагч хатагтай Сезин Синаноглу Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт Итгэмжлэх захидлаа гардуулав.
- 2010.07.19 АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч Жэймс Стайнберг Монголд хийж буй ажлын айлчлалынхаа хүрээнд Ерөнхий сайд С.Батболд, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар нарт тус тус бараалхав. Уулзалтуудын үеэр хоёр тал Монгол, Америкийн харилцааны өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөхийн зэрэгцээ ардчилал, хүний эрх, эрх чөлөөний нийтлэг үнэ цэнэд суурилсан иж бүрэн түншлэлийн харилцааг бүхий л салбарт үргэлжлүүлэн хөгжүүлэх сонирхолтой байгаагаа нотолж, Монгол Улсын гадаад бодлого, Төв Ази болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын зарим асуудлуудаар санал солилцов.
- 2010.07.18-20 Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит XIV хуралдаан Улаанбаатар хотноо болов. Хуралдааныг ЗГХК-ын Монголын хэсгийн тэргүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Оросын хэсгийн тэргүүн ОХУ-ын Тээврийн сайд И.Е.Левитин нар даргалав. Энэ удаагийн хуралдаанаар ЗГХК-ын XIII хуралдааны шийдвэрийн биелэлт, бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаа, Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлууд, хоёр талын худалдааг хөгжүүлэх арга хэлбэр, ЗГХК-ын бүтцийг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх зэрэг асуудлыг хоёр талын мэргэжилтнүүд хэлэлцэж, тодорхой тохиролцоонд хүрэв.
- 2010.07.22-23 Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар БНСВУ-ын нийслэл Ханой хотноо болсон АСЕАН-ы Бүсийн чуулга- АРФ-ын сайд нарын 17 дугаар уулзалтанд оролцов. Уулзалтын үеэр Гадаад харилцааны сайд Г.Занданшатар Япон улсын Гадаад хэргийн сайд К.Окада, ЕХ-ны төлөөлөгчдийг тэргүүлж буй БНУнгар Улсын Гадаад хэргийн сайд Мартоны Янош нартай тус тус уулзаж харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

- 2010.08.19-23 Монгол Улсын Засгийн газрын урилгаар ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд ноён Дирк Нийбел тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын хүрээнд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд Д.Нийбел Монгол Улсын Ерөнхий сайдад бараалхаж, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд нартай уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.
- 2010.08.29-30 Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатарын урилгаар Япон Улсын Гадаад хэргийн сайд К.Окада Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Ноён К.Окада Гадаад харилцааны сайд Г.Занданшатартай хэлэлцээ хийж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа болон бүс нутаг, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. Мөн айлчлалын үеэр тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд нарт бараалхав.
- 2010.09.17 Туркийн Истанбул хотод шинээр байгуулагдаж буй Монгол Улсын Өргөмжит консулын газрын нээлт болов. Нээлтэд Монголын талаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Элчин сайд О.Очиржав, БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Батболд, ЭСЯ-ны ажилтан болон Истанбулд сурч буй монгол оюутны төлөөлөл, Туркийн талаас Өргөмжит консулаар томилогдож буй Ф.А.Арман, Анталья дахь Монголын Өргөмжит консул Ө.Айдинэр, “Айдинэр” компанийн Монгол дахь төлөөлөгч Г.Өзгэн, Гадаад эдийн засгийн харилцааны зөвлөлийн ажилтан А.Кула, мөн Олон улсын цагаачлалын албаны Истанбул дахь төлөөлөгч Р.Анжелина нар оролцов.
- 2010.09.22 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 65 дугаар чуулганы хүрээнд болсон “Нэн эмзэг орнуудын онцгой хэрэгцээг хангах нь” сэдэвт дугуй ширээний уулзалтад оролцож байр сууриа илэрхийлэв. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Нью-Йорк хотноо Мянганы Сорилтын корпорацын шинэ гүйцэтгэх захирал Д.Иоханес тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр АНУ манай улсын ардчиллыг эхнээс нь тууштай дэмжиж ирснийг болон тус улсаас хэрэгжүүлж байгаа Мянганы сорилтын сангийн хөтөлбөр Монголын ард түмний амьдралд шууд нөлөөлөх чухал ач холбогдолтойг Ерөнхий сайд онцлон тэмдэглэв. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар АНУ-ын Эрчим хүчний дэд сайд Даниэл Понеманыг хүлээн

авч уулзаж хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Г.Занданшатар, АНУ-ын Эрчим хүчний дэд сайд Даниэл Понеман нар “Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурав.

2010.09.27-10.01 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Канад Улсад албан ёсны айлчлал хийв. Ерөнхий сайд С.Батболдын Канад Улсад хийсэн айлчлал нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувьд тус улсад хийж буй анхны айлчлал болж байгаагаараа чухал ач холбогдолтой байв. Уг айлчлалын үеэр Монгол Улс, Канад Улсын хооронд тогтсон найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, хоёр орны ардчилал, зах зээлийн эдийн засаг, НҮБ-ын дүрмийн түгээмэл зарчмуудыг хоёр талын харилцаандаа удирдлага болгон баримталж хоёр талын дээд хэмжээний улс төрийн яриа хэлцээний давтамжийг хадгалах, харилцааны эрх зүйн таатай орчныг бэхжүүлэх, хоёр талын харилцааг өргөн хүрээтэй түншлэлийн хамтын ажиллагааны зарчмаар цар хүрээг нь өргөтгөн хөгжүүлэх, харилцааны өнөөгийн түвшин, хэтийн төлвийг тодорхойлох, ялангуяа худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, хүнс, хөдөө аж ахуй, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны болон олон улс, бүс нутгийн зарим асуудлуудаар санал солилцов.

2010.10.04-06 Женев хотноо Олон улсын парламентын холбооны ээлжит 123 дугаар Ассемблейд Улсын Их Хурлын дэд дарга Н.Энхболд тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид оролцов. Хүн амын шилжилт хөдөлгөөн ба хөгжлийн асуудалд парламентын гүйцэтгэх үүрэг, улс төрийн намууд ба сонгуулийн кампанийг санхүүжүүлэхэд ил тод, хариуцлагатай хандахын ач холбогдол зэрэг хэд хэдэн чухал сэдвийг хэлэлцэв. Чуулганы үеэр Монголын төлөөлөгчдийн тэргүүн Н.Энхболд ОУПХ-ны удирдлага, зарим улсын төлөөлөгчдийн тэргүүн нартай уулзаж ярилцлаа.

2010.10.06 Бүгд Найрамдах Финланд Улсын Ерөнхийлөгч хатагтай Тарья Халонены урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Финланд Улсад Төрийн айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Финланд Улсын Ерөнхийлөгч хатагтай Тарья Халонентой ганцаарчилсан уулзалт хийсэн бөгөөд хоёр талын төлөөлөгчид өргөтгөсөн хэлэлцээ хийв. Хэлэлцээнд Монголын талаас УИХ-ын гишүүн, Гадаад

харилцааны сайд Г.Занданшатар, УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Э.Мөнх-Очир, ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай, БСШУ-ны дэд сайд Ч.Куланда, Финландын талаас Гадаад худалдаа хөгжлийн сайд П.Вайринен, Төрийн нарийн бичгийн дарга П.Торстила, Финланд Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Л.Бэкстрүм, ГХЯ-ны Ази, Номхон далайн хэлтсийн захирал Ёохан Шалин болон албаны бусад хүн оролцов.

2010.10.11 Монгол Улс, Европын Холбооны Хамтарсан хорооны ээлжит XIII хуралдаан Улаанбаатар хотноо болов. Хуралдааныг Монгол Улс, Европын Холбооны Хамтарсан Хорооны Монголын хэсгийн тэргүүн, Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Европын комиссын Гадаад харилцааны Ерөнхий газрын Монголын хэлтсийн дарга Ф.Жессен нар тэргүүлж оролцов. Хуралдаанаар Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал болон гадаад бодлого, Европын Холбооны улс төр, эдийн засгийн байдал болон гадаад бодлогын талаар харилцан мэдээлэл солилцож, 2007-2010 оны Хөгжлийн хамтын ажиллагааны баримжаалсан хөтөлбөрийн хэрэгжилт, 2011-2013 оны Хөгжлийн хамтын ажиллагааны баримжаалсан хөтөлбөрийн чиглэл, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаар ярилцав. Мөн хоёр талын харилцааны өнөөгийн байдал, харилцааг цаашид өргөжүүлэх боломж, хэрэгжүүлэх бололцоо бүхий төслүүдийн, түүний дотор байгаль орчин, тээвэр, хүнс, соёл зэрэг салбарын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын талаар санал солилцов.

2010.10.12-14 Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад худалдааны сайд хатагтай Анн-Мари Идрак Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Францын Гадаад худалдааны сайдын энэхүү айлчлал нь Монгол Улсад хийж буй анхны айлчлал юм. Айлчлалын үеэр Монгол-Францын бизнес чуулга- уулзалтыг ГХЯ-ны Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Францын UBIFRANCE /францын аж ахуйн нэгж, компаниудын гадаад зах зээл дахь үйл ажиллагааг дэмждэг төрийн байгууллага/ хамтран зохион байгуулсан бөгөөд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар ярилцаж санал солилцохын зэрэгцээ цөмийн энергийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр болон онцгой байдлын салбарт хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Санамж бичигт гарын үсэг зурав.

2010.10.18 Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар, БНХАУ-ын Засаг

- Захиргааны Тусгай Бүс Макаогийн Аюулгүй байдлын нарийн бичгийн дарга Чеон Куок Ва нар Хүн худалдахтай тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын ЗТБ Макаогийн Засгийн газар хоорондын хэлэлцээрт Макао хотноо гарын үсэг зурав.
- 2010.10.21 Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын зөвлөлдөх комисс /ЗГХЗК/-ийн ээлжит хуралдаан Улаанбаатар хотноо болов. Хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийг ЗГХЗК-ийн Монголын хэсгийн дарга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, БНАСАУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийг зөвлөлдөх комиссын Солонгосын хэсгийн дарга, БНАСАУ-ын Гадаад худалдааны дэд сайд Гү Бон Тэ нар тэргүүлж оролцов. Хуралдаанаар зөвлөлдөх комиссын 7 дугаар хуралдааны шийдвэрийн биелэлтэд үнэлэлт дүгнэлт хийсний зэрэгцээ 2011-2012 онд Монгол Улс, БНАСАУ-ын хооронд эдийн засаг, худалдаа болон шинжлэх ухаан-техникийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлууд, тухайлбал, хоёр орны хооронд бараа солилцоо, худалдааг өргөжүүлэх, ажиллах хүчний асуудал болон газар тариалан, усжуулалт, далайн тээвэр мөн уламжлалт анагаах ухаан, ойжуулалтын салбар, төмөр замын өргөтгөл шинэтгэл, бүтээн байгуулалтын чиглэлээр солонгосын талтай санал солилцож, хэрэгжих боломжтой, үр дүнгээ өгөх асуудлаар тодорхой тохиролцоонд хүрэв.
- 2010.11.15-19 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, гэргий Х.Болормаагийн хамт Япон улсын Засгийн газрын урилгаар Япон улсад төрийн айлчлал хийв. Айлчлалынхаа үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Японы Цог Жавхлант Эзэн хаан Акихитод бараалхаж, Ерөнхий сайд Н.Кантай албан ёсны хэлэлцээ хийв. Мөн тэрбээр Япон улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Ёкомичи болон Зөвлөхүүдийн танхимын дарга Т.Нишиока нартай уулзаж, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.
- 2010.11.17 Бүгд Найрамдах Итали Улсын Милан хотод Монгол Улсын Өргөмжит консулын газрын нээлт болов. Нээлтийн ажиллагаанд Монгол Улсаас БН Итали Улсад хавсран суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Энхсайхан, Миланд албан ёсны айлчлал хийж буй Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нар оролцов.
- 2010.11.25 Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн ээлжит хуралдаан Бүгд Найрамдах Тажикстан Улсын

нийслэл Душанбе хотод болов. Хуралдаанд манай талаас Гадаад харилцааны сайд Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

- 2010.12.06-09 Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар Тайландын Вант Улсын Гадаад хэргийн сайд Касет Пиромягийн урилгаар Тайландын Вант Улсад албан ёсны айлчлал хийв. Энэ удаагийн айлчлал нь Монгол Улсын Гадаад харилцааны сайдын тус улсад хийж буй анхны айлчлал байв.
- 2010.12.13-16 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путины урилгаар Оросын Холбооны Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын явцад Монгол, Оросын Засгийн газрын тэргүүн нарын хэлэлцээ болов. Талууд 2011 онд Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 90 жил, сансрын хамтарсан нислэгийн 30 жилийн ойг хамтран тэмдэглэхээр тохиролцов.
- 2010.12.15 Монгол Улсаас Хорват Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Энхсайхан Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч Иво Йосоповичид Итгэмжлэх жуух бичгээ өргөн барив. Итгэмжлэх жуух бичгээ барьсны дараагаар Ерөнхийлөгч Иво Йосопович Элчин сайдтай тусгайлан уулзаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцов. Уулзалтын үеэр Ерөнхийлөгч Иво Йосопович Монгол Улсаас анхны Элчин сайд Итгэмжлэх жуух бичгээ барьж байгааг дурдаад хэдийгээр Монгол Улс, Хорват Улс нь газар зүйн байршлын хувьд алс оршдог боловч хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх бүрэн бололцоо байгааг тэмдэглэв.
- 2010.12.20 Монгол Улс, Европын Холбооны хооронд байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-т хоёр тал Улаанбаатар хотноо гарын үсэг зурав. Энэхүү хэлэлцээр нь хоёр талын харилцан сонирхсон хамтын ажиллагааны салбарууд, тухайлбал эдийн засаг, санхүүгийн үйлчилгээ, татвар, аж үйлдвэрийн бодлого болон жижиг, дунд үйлдвэр, мэдээлэлжсэн нийгэм, шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёл, эрчим хүч, тээвэр, байгаль орчин, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, статистик зэрэг хамтын ажиллагааны олон салбарыг хамаарав.